



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/350

Мандалговь

Сургалтын байгууллагын захиралд
мэргэжлийн зэрэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-ын 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын арга зүйн зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн 2019-2020 оны хичээлийн жилд "Тэргүүлэх", "Заах аргач" мэргэжлийн зэрэг шинээр олгох сургалтын байгууллагын захирлуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 2020 оны төсвийн саналд тусгаж, тухайн оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс тооцон олгохыг сургалтын байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (Ц.Бумангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191030

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 24 -ний өдрийн 1360 дугаар
захирамжийн хавсралт



МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ШИНЭЭР ОЛГОХ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРЛУУДЫН НЭРС

№	Нэр	Байгууллага, албан тушаал
Нэг. "Тэргүүлэх" мэргэжлийн зэрэг		
1	М.Энхбаяр	Сайнцагаан сумын Мандал сургуулийн захирал
Хоёр. "Заах аргач" мэргэжлийн зэрэг		
1	Н.Долгоржав	Луус сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал
2	Ц.Баянзөв	Хулд сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал
3	Л.Буянтогтох	Эрдэнэдалай сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал
4	Ж.Өлзийжаргал	Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал